



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 11 өдөр

Дугаар А/155

Шивээговь сум

“Малчдын нэг өдөр” сургалт сурталчилгаа,
спортын арга хэмжээ зохион байгуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаал “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.5, 4.5.12, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн “Сумын 2023 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын “Малчдын нэг өдөр” сургалт сурталчилгаа, спортын арга хэмжээг 2023 оны 10 дүгээр сарын 13-ны өдөр зохион байгуулсугай.

2.Арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

- Ажлын хэсгийн ахлагч: Д.Отгонжаргал
(Засаг даргын Тамгын газрын дарга)
- Гишүүд: Л.Бадамханд
(1 дүгээр багийн Засаг дарга)
- С.Отгонбаатар
(2 дугаар багийн Засаг дарга)
- Д.Мөнхзаяа
(Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн)
- Д.Баттуул
(Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн)
- Л.Түмэнцэцэг
(Соёлын төвийн дарга)
- Б.Баярцэцэг
(Нярав)
- Нарийн бичгийн дарга: П.Ганжаргал
(Мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт, менежмент, малын үржил


бүртгэлийн асуудал хариуцсан
мэргэжилтэн)

3.Арга хэмжээний хөтөлбөрийн удирдамжийг 1 дүгээр, төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

4.Арга хэмжээнд зарцуулагдах 800,000 (найман зуун мянга) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн Малын тоо толгойн албан татварын зардлаас зохих журмын дагуу гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал), нягтлан бодогч (Л.Цэнд-Аюуш) нарт зөвшөөрсүгэй.

5.Арга хэмжээг чанартай зохион байгуулж, үйл ажиллагааны үр дүнг тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Д.Отгонжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Ч.СУГАРМАА



**ШИВЭЭГОВЬ СУМЫН 1, 2-Р БАГИЙН МАЛЧИН ИРГЭДЭД ХҮРГЭХ
“МАЛЧНЫ НЭГ ӨДӨР” СУРГАЛТ, ӨДӨРЛӨГИЙН ХҮРЭЭНД
ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ УДИРДАМЖ**

Нэг. Зорилго

Малчин болон мал бүхий иргэдэд Төрийн үйлчилгээ, орон нутгийн өнөөгийн байдал, Төр засгаас авч хэрэгжүүлж буй хууль тогтоомжийн талаар мэдээ мэдээлэл сургалтыг нэг дор хүргэх, малчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд оршино.

Сургалтаар:

- Ногоон тэжээл тариалах аргачлал
- Гар тэжээл хэрхэн бэлтгэх тухай заавар зөвлөмж гарын авлага
- Бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж буй үлийн цагаан оготной байгальд халгүй аргаар тэмцэх зөвлөмж
- Малын хөлийн татварын тухай хуулийн мэдлэг олгох сургалт
- Малын индексжүүлсэн даатгалын тухай, түүний ач холбогдол

Хоёр. Хугацаа

2023 оны 10 сарын 13-ны өдөр Шивээговь сумын 2 дугаар багийн нутагт байрлах **“Олон тойрмын хэц”** хэмээн газарт зохион байгуулагдана.

Гурав. Хамрах хүрээ

Шивээговь сумын 1, 2-р багийн малчид болон мал бүхий иргэд

Дөрөв. Тавигдах шаардлага

Малын тоо толгойн албан татварын хуулиар тэмцээнд оролцох малчдыг зохион байгуулагчдын зүгээс баг болгон хуваарилна. Малчид тус арга хэмжээнд ирэхдээ биед эвтэйхэн, дулаан, биеийн тамирын хувцастай ирнэ.

Тав. Шагналын сан


Тэмцээнд баг бүрээс тоо заасан малчид орох бөгөөд багийн нийт дүнгээр эхний 2 байр шалгаруулж өргөмжлөл, дурсгалын зүйлээр шагнаж урамшуулна.

Зургаа. Тэмцээний төрөл

- Баг бүр мэндчилгээтэй байна.
- Хөгжөөнт буухиа /тухайн үед оролцох хүний тоо заана/
- Хазаар зангидах
- Чөдөр зангидах
- Хөгжөөнт тоглоом
- АХА тэмцээн

Жич: Баг тус бүр идээ засах бөгөөд өрх бүр цагаан идээгээ авчрах, хазаар чөдөр зангидах сур авчрах, мэндчилгээнд шаардлагатай хөгжим, хэрэгсэлээ хувиасаа бэлдэх. Шүүгчдийн зүгээс Багийн эмх цэгц, эв нэгдлийг харж дүгнэнэ. Шүүгчидтэй маргаан үүсгэхгүй байхыг анхаарна уу.

Сумын Засаг даргын 2023 оны 10
дугаар сарын 11 -ний 1155 дугаар
захирамжийн 2-р хавсралт



Малчдын өдөрлөг, сургалтын төсөв

Техник хэрэгсэл

2023.10.11

№	Тоног төхөөрөмж	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт дүн
1	Мотор	Л	20	2,560	51,200
2	Портер	Л	15	3,770	56,550
3	Суудлын машин	Л	20	2,560	51,200
	Дүн				158,950

Бичиг хэрэг

1	Бичгийн цаас	Боодол	1	18,000	18,000
2	Бал	Ширхэг	10	4,505	45,050
3	Принтерийн хор	Ширхэг	4	12,000	48,000
	Дүн				111,050

Шагнал урамшуулал

1	1-р байр			250,000	250,000
2	2-р байр			150,000	150,000
3	Тусгай байр			100,000	100,000
4	Жааз	Ширхэг	3	10,000	30,000
	Дүн				530,000
	Нийт дүн				800,000